



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

### Г “Номад фанд” хувийн хөрөнгө Г оруулалтын санг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Хорооны 2015 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2 дугаар зүйлийн 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Номад капитал ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Номад фанд” хувийн хөрөнгө оруулалтын санг бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-г үүрэг болгосугай.

2. Хөрөнгө оруулалтын санг бүртгэсэнтэй холбоотойгоор санг үүсгэн байгуулах ажиллагааг гүйцэтгэж, холбогдох хууль, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, мэргэжлийн өндөр ёс зүйтэй ажиллахыг “Номад капитал ҮЦК” ХХК /М.Цолмон/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт мэдээлэл хүргэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,  
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

